



АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ

АНГЛИ ХЭЛНИЙ ҮГ ҮСЭГЛЭЛИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Англи хэл эхлэн суралцаж буй сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэх, үгийг нүдлэн тогтоох, зөв дуудаж сурах, англи хэл сурах сонирхлыг төрүүлэх, Пийрсон хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Америкийн үндэсний үсэглэлийн тэмцээнийг орон нутгийн сурагчдад танин мэдүүлэх, аймгийн аварга суралцагчдыг шалгаруулахад оршино.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ТАЛУУД

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1, 2, 12 дугаар сургууль

Энх тайвны корпусын сайн дурын мэргэжилтнүүд

ГУРАВ. ХУГАЦАА

2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Хэрлэн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд дараах цагийн хуваарийн дагуу, дараах ангиллаар явагдана.

5 дугаар анги 14.00 цагт

6 дугаар анги 14.00 цагт

7 дугаар анги 16.00 цагт тус тус эхэлнэ.

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн Пийрсон хөтөлбөрөөр суралцаж буй 5, 6, 7 дугаар ангийн суралцагчид

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- Үг үсэглэлийн тэмцээнийг Америкийн үндэсний үсэглэлийн тэмцээний дүрмээр явуулах бөгөөд сургуулиуд төрөл тус бүрт 1-7 хүртэлх суралцагчийг оролцуулж болно.
- Үгсээс хөтөлөгч 3 удаа үгийг хэлж өгнө. Хэрэв оролцогч үгийн утгыг ойлгож сонсоогүй тохиолдолд тайлбарлуулах хүсэлтийг 1 удаа тавина. Үгийг 1 удаа алдсан тохиолдолд тэмцээнээс хасагдана.
- Үг үсэглэх дарааллыг тэмцээн эхлэхийн өмнө суралцагчид өөрсдөө сугална.
- Тэмцээний туршид анги бүрт зохион байгуулагч сургуулиудаас "Dornod foreign language teachers" цахим группээр дамжуулан live хийж дамжуулна.
- Тэмцээнд ашиглагдах үгс: 5 дугаар анги Wider World Starter, 6 дугаар анги Wider World 1, 7 дугаар анги Wider World 2 сурах бичгийн Unit 1-10 сэдвийн хэрэглээний үгс

ЗУРГАА. БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

2025 оны 04 дүгээр сарын 22-ны 17.00 цаг хүртэл онлайнаар бүртгэнэ.

Мандатны үнэ: 1 сурагч 3000 төгрөг

ДОЛОО. Шагнал урамшуулал:

Ангилал тус бүрд шилдэг 7 оролцогч шалгаруулж, Зүүн бүсийн тэмцээнд оролцох эрхийн бичиг олгоно.